



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 12-өдөр

Дугаар А/644

Булган сум

Г Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг Г
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

| | |
|-----------------------|---|
| Дарга: | Б.Ариун-Эрдэнэ (Аймгийн Засаг дарга) |
| Орлогч дарга: | М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга) |
| Гишүүд: | Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга) |
| | Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга) |
| | Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга) |
| | П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга) |
| | Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга) |
| | Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга) |
| | Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга) |
| | Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга) |
| | Т.Дэлгэрмаа (Насан туршийн боловсролын төвийн захирал) |
| | П.Саран (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Оргил- Мээж” ТББ-ын тэргүүн) |
| Нарийн бичгийн дарга: | Д.Очирбат Хараагүйчүүдийн салбар зөвлөлийн тэргүүн) А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого зохицуулалт) |

хариуцсан мэргэжилтэн)

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг салбар дундын оролцоотойгоор хэрэгжүүлэн, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зохион байгуулсан ажлын тайланг заасан хугацаанд аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж, ажиллахыг салбар зөвлөлийн орлогч дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 30-ны өдрийн А/121 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ